



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Талын замын ТӨХК-ны 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СБА-2025/003/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn
Баруун-Урт хот
2025 он

Дарга,
тэргүүлэх аудитор: Г.Даваа
Утас: 70518396
Аудитын менежер: М.Нарантуяа
Утас: 70512123
Аудитор: Б.Мөнхбамбар
Утас: 70512123

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	7
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
3.1 Албан шаардлага	8
3.2 Зөвлөмж	9
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	11

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6 давхарт, Нутгийн удирдлагын 2 дугаар байр,
Балдан-Осорын гудамж, 7 дугаар баг,
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075
Утас: (976) 70518396
Цахим шуудан: sukhbaatar@audit.gov.mn

2025.03.31 № 353

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Талын зам ТӨХК-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, тодруулгыг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Харилцагч байгууллагатай 249.0 сая төгрөгийн авлагын тооцоог актаар баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу 70.7 сая төгрөгийн ажил гүйлгээг толилуулсан, эдийн засгийн зорилтот түвшний хязгаарыг хэтрүүлэн зарцуулсан, ер төлбөр үүсгэхгүй байх зарчмыг баримталж үйл ажиллагааг зохион байгуулаагүй зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.5, 20.2.6 дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5 дахь заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын болон батламж мэдэгдлийн түвшинд “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх”, “толилуулга”, “оршин байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг

Авто зам засвар арчлалтын ажилд машин, механизм, техник түрээсээр авч ашиглаж байгаа боловч түрээсийн зах зээлийн үнийн судалгаа, харьцуулалт хийгээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалттай нийцэхгүй байна.

Аудитын гол асуудал

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 794 дүгээр тогтоолоор баталж, тайлант онд 2,115.0 сая төгрөгийн нийт орлого, 2,107.9 сая төгрөгийн нийт зардалтай, 6.4 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 2,199.0 сая төгрөгийн орлого, 2,536.4 сая төгрөгийн зардалтай ажиллаж, 337.4 сая төгрөгийн алдагдал хүлээжээ.

Бусад асуудал хэсэг

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөөр батлагдсан хөрөнгө оруулалтын ажлаас 95.0 сая төгрөгийн өөрөө буулгагч хово, 8 сая төгрөгийн гар нягтруулагч зэргийг худалдан аваагүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, тодруулга нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Г.ДАВАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2,128,662.82	10,173,287.26
1.1.2	Дансны авлага	5,083,782.06	274,430,520.33
1.1.6	Бараа материал	323,464,354.92	469,147,937.17
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/Тооцоо	-	.
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	312,705,431.12	312,705,431.12
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	643,382,230.92	1,066,457,175.86
1.2.1	Үндсэн хөрөнгө	875,957,587.71	838,286,171.70
1.2.2	Биет бус хөрөнгө	224,340,000.00	227,081,111.16
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,100,297,587.71	1,065,367,282.86
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,743,679,818.63	2,131,824,458.74
2.1.1.1	Дансны өглөг	145,538,542.30	737,929,963.24
2.1.1.3	Татварын өр	157,720,277.38	194,966,126.66
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	303,258,819.68	932,896,089.90
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	21,445,411.00	
2.2	Өр төлбөрийн нийт дүн	324,704,230.68	932,896,089.90
2.3.1	Өмч: -төрийн	1,174,228,729.26	1,419,824,140.26
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	242,135,306.17	338,036,729.71
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	224,150,000.00	
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(221,538,447.48)	(558,932,501.13)
2.3.10	Эзэмшигчдийн өмчийн дүн	1,418,975,587.95	1,198,928,368.84
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	1,743,679,818.63	2,131,824,458.74

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Өмнөх он	Тайлант оны гүйцэтгэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,445,935,422.82	2,198,996,552.36
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,128,498,645.85	1,700,263,376.42
3	Нийт ашиг (алдагдал)	317,436,776.97	498,733,175.94
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	23,060,000.00	
9	Борлуулалт маркетингийн зардал	182,244,916.74	365,314,268.46
10	Ерөнхий ба удирдлагын зардал	154,757,362.92	372,737,228.13
11	Санхүүгийн зардал	242,534.50	285,700.00
12	Бусад зардал	1,590,000.00	97,790,033.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		

15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)			-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		-	-
17	Бусад ашиг (алдагдал)		-	
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,661,962.81	(337,394,053.65)	
19	Орлогын татварын зардал	166,196.33	-	
20	Татварын дараах ашиг (алдагдал)	1,495,766.48	(337,394,053.65)	
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал		-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	1,495,766.48	(337,394,053.65)	
23	Бусад дэлгэрэнгүй орлого		-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		-	-
24	Орлогын нийт дүн			
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		-	-
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		-	-
23.3	Бусад олз (гарз)		-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нөөц	Гадаад валют хөрвүүлэлтийн нөөц	Бусад	Хуримтлагдсан дүн	Нийт дүн
1	2023 ОНЫ 1-Р САРЫН 1-ЭЭРХ ҮЛДЭГДЭЛ	-	-	-	-	-	-	-	-
2	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-	-	-	-
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	-	-	-
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-	-	-
7	Зарлагдсан ногдол ашиг	-	-	-	-	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	-	-	-	-	-
9	2023 ОНЫ 12-Р САРЫН 31-ЭЭРХ ҮЛДЭГДЭЛ	1,174,228,729.26	-	-	242,135,306.17	-	224,150,000.00	(221,538,447.48)	1,418,975,587.95
10	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	224,150,000.00	-	-	-	-	(224,150,000.00)	-	-
11	Залруулсан үлдэгдэл	1,398,378,729.26	-	-	242,135,306.17	-	-	(221,538,447.48)	1,418,975,587.95
12	Тайлант үеийн ашиг (алдагдал)	-	-	-	-	-	-	(337,394,053.65)	(337,394,053.65)
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	21,445,411.00	-	-	-	-	-	-	21,445,411.00
15	Зарлагдсан ногдол ашиг	-	-	-	-	-	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	95,901,423.54	-	-	-	95,901,423.54
17	2024 ОНЫ 12 САРЫН 31-ЭЭРХ ҮЛДЭГДЭЛ	1,419,824,140.26	-	-	338,036,729.71	-	-	(558,932,501.13)	1,198,928,368.84

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Балансын үзүүлэлт	Өмнөх он	Тайлант оны гүйцэтгэл
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	1,755,837,341.86	1,928,438,798.00
1.1 Мөнгөн орлогын дүн	1,755,837,341.86	1,928,438,798.00
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	486,607,757.00	1,923,190,793.00
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	78,708.00	2,486,305.00
Татаас, санхүүжилтийн орлого		1,582,470,230.00
Орон нутгаас/орлого/	189,457,454.86	340,720,563.00
бусад/орлого/		2,761,700.00
1.2 Мөнгөн зарлагын дүн	1,746,785,339.53	2,158,848,809.92
Ажиллагчдад төлсөн	356,976,380.13	455,978,513.70
Нийгмийн даатгалын байгуулгад төлсөн	116,100,739.10	131,669,411.52

Бараа материал худалдан авахад төлсөн	832,102,975.82	291,849,952.55
Ашиглалтын зардал төлсөн	9,390,901.87	9,993,729.55
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	333,642,857.60	538,850,520.97
Хүүний төлбөрт төлсөн		97,790,033.00
Татварын байгуулгад төлсөн	33,377,166.23	88,540,235.09
Даатгалын төлбөрт төлсөн		2,486,305.00
Бусад мөнгөн зарлага	65,194,318.78	541,690,108.54
1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	9,052,002.33	(230,410,011.92)
2.Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(10,506,645.46)	(11,545,363.64)
Мөнгөн зарлагын дүн	10,506,645.46	11,545,363.64
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	10,506,645.46	11,545,363.64
2.20 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(10,505,645.46)	(11,545,363.64)
3.Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		250,000,000.00
Мөнгөн орлогын дүн		700,000,000.00
Зээл авсан өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		700,000,000.00
Мөнгөн зарлагын дүн		450,000,000.00
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		450,000,000.00
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		250,000,000.00
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(1,454,643.13)	8,044,624.44
Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,583,305.95	2,128,662.82
Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,128,662.82	10,173,287.26

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2024 оны төлөвлөгөө	2024 оны жилийн эцсийн гүйцэтгэл	Гүйцэт - гэлийн хувь
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт				
	Үндсэн үйлдвэрлэл	Төгрөг	2,115,075,200.00	2,198,996,552.36	104%
	Үүнээс: Улсын чанартай АЗЗА	Төгрөг	1,515,075,200.00	1,582,470,230.00	104%
	Орон нутгийн чанартай АЗЗА	Төгрөг	600,000,000.00	616,526,322.36	103%
	Торгууль/Зам эвдсэн/ Нийт орлого	Төгрөг		-	
2	Нийт зардал	Төгрөг	2,107,986,900.00	2,536,390,606.01	120%
	Үүнээс: Удирдлагын зардалд	Төгрөг	232,033,300.00	372,737,228.13	
3	Татварын өмнөх ашиг	Төгрөг	7,088,300.00		0%
4	Цэвэр ашиг /алдагдал/	Төгрөг	6,379,400.00	(337,394,053.65)	
5	Төсвийн төлбөр	Төгрөг	279,457,000.00	220,209,647.51	79%
	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	Төгрөг	708,800.00		0%

	Нэмэгдсэн өртгийн албан татвар	Төгрөг	46,904,500.00	75,232,653.13	160%
	Газрын төлбөр	Төгрөг	-	1,069,950.00	
	Агаарын бохирдлын төлбөр	Төгрөг	-	89,000.00	
	Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэл	Төгрөг	171,368,200.00	131,669,411.52	77%
	ХХОАТ	Төгрөг	54,401,500.00	8,597,531.62	16%
	Үл хөдлөх хөрөнгийн татвар	Төгрөг	3,902,000.00	1,804,798.24	46%
	Тээврийн хэрэгслийн татвар	Төгрөг	1,350,000.00	956,303.00	71%
	АМНАТ	Төгрөг	-		
	Бусад	Төгрөг	822,000.00	790,000.00	96%
6	Төрийн өмчийн ногдол ашиг	Төгрөг	3,189,700.00		0%
7	Ажиллагсдын тоо	хүн	37.00	32.00	0%
8	Нийт цалингийн сан	Төгрөг	659,108,400.00	555,175,395.00	84%
	Нэг ажилтны сарын дундаж цалин	Төгрөг	1,484,500.00	1,492,406.97	101%
9	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал	Төгрөг			
10	Хөрөнгө оруулалт	Төгрөг	113,200,000.00	11,545,363.64	10.2%
11	Нийт авлага	Төгрөг	27,571,300.00	274,430,520.33	
12	Нийт өглөг	Төгрөг	37,639,700.00	932,896,089.90	
	Үүнээс: Богино хугацаат өр төлбөрт	Төгрөг	16,194,300.00	932,896,089.90	
	Үүнээс: Урт хугацаат өр төлбөрт	Төгрөг	21,445,400.00	-	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,586.5 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 334.1 сая төгрөгийн алдааг залрууллаа.

Үүнд:

- Кувейтийн сангийн хөрөнгөөр 2009 онд нийлүүлэгдсэн 21.4 сая төгрөгийн машин механизм, тоног төхөөрөмжийг урт хугацаат өр төлбөрөөр бүртгэн байсныг эздийн өмч хэсэгт залруулж бүртгэв.
- Үндсэн хөрөнгөд алдаатай бүртгэсэн дуусаагүй замын ажил буюу орон нутгийн замын гүйцэтгэлийг бусад эргэлтийн бус хөрөнгөд 312.7 сая төгрөгөөр залруулга

3.1 Албан шаардлага

3.1.1 Тус байгууллагын мөнгөн кассын тайланд 70.7 сая төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээг толилуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.1.4-т "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх"; заалтыг зөрчсөн байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

3.1.2 Санхүүгийн тайланд 249.0 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д /дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;/, мөн хуулийн 20.2.6-д /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ заасныг тус тус зөрчсөн байна.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.2.1. Цахим худалдан авалттай холбоотой

Илрүүлэлт:

Тайлант онд 8.5 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан боловч цахим дэлгүүрийг ашиглаагүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийн шаардлагад нийцээгүй байна. Энэ нь цахим дэлгүүрт худалдаалагдаж буй бараа, бүтээгдэхүүний үнийн түвшин бусад нийлүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудтай харьцуулахад хэт өндөр, сонголт хангалтгүй, шаардлагатай техникийн үзүүлэлт бүхий бараа, бүтээгдэхүүн бүрдээгүйтэй холбоотой байна. Мөн шалгагдагч байгууллага цахим дэлгүүрт өөрт тохирсон үзүүлэлттэй бараа, бүтээгдэхүүн байхгүй тохиолдолд цахим худалдан авах ажиллагааны нэгжид холбогдох журмын дагуу санал гаргах, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүргээ бүрэн биелүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн худалдан авах ажиллагааны газарт (ТХААГ) цахим дэлгүүрийн барааны нэр төрөл, сонголтыг өргөжүүлэх талаар албан бичиг хүргүүлж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах. Мөн Бараа, үйлчилгээний зах зээлийн судалгааг урьдчилан хийж, худалдан авах барааны жагсаалтыг нарийвчлан боловсруулж, сонголт хийх боломжоор хангуулах ажлыг цахим дэлгүүрт хүргүүлж, худалдан авалтыг зохион байгуулах.

3.2.2.Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тээвэр шатахууны зарцуулалтыг жолоочийн тооцооны хуудсанд холбогдох арга зүй, стандартын дагуу үнэн зөв хөтөлж, ямар ажлаар хаашаа явсныг тодорхой бичиж толилуулаагүй зөрчил дутагдал илэрсэн. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал заалтуудыг тус тус зөрчжээ.

Өгсөн зөвлөмж:

Тээвэр шатахууны зардлыг зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, замын хуудсыг тодорхой бичиж, зардлыг бууруулах арга хэмжээ авах

3.2.3.Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Албан хаагчдыг сарын үндсэн цалингаас илүү хэмжээний цалингийн урьдчилгаа олгож байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-д "үнэн зөв байх" Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 "Цалин хөлс нь үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, ээлжийн амралтын цалин, шагнал урамшууллаас бүрдэнэ", 104 дүгээр зүйлийн 104.1 "Цалин хөлсийг сард хоёроос

доошгүй удаа тогтсон өдөр олгох бөгөөд олгох өдрийг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ, эсхүл хөдөлмөрийн гэрээнд тусгана” гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Авлага үүссэн албан хаагчдаас хуваарь гарган авлагыг төлүүлэх, цалингийн урьдчилгааг 1 сарын дүнгээс өндөр дүнгээр олгохгүй байх

3.2.4.Зардлын данстай холбоотой

Илрүүлэлт:

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнээр батлагдсан хөрөнгөөс хэтрүүлэн зарцуулж 337.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 794 дүгээр тогтоолыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Үйл ажиллагааг үр ашигтай байлгах ажлыг зохион байгуулж, эдийн засгийн зорилтот түвшний хэрэгжилтийг тогтмол шинжилж, гүйцэтгэлийн тайлан гаргах замаар зохистой удирдлагыг хангах

3.2.5.Өр төлбөртэй холбоотой

Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагааг зохистой удирдаж, өр авлага үүсгэхгүй байх зарчмыг баримталж үйл ажиллагаа зохион байгуулалгүй, 932.9 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5 (*хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж, өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх*) болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 (*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*) заалтуудыг зөрчсөн ба оршин байх, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Өр төлбөрийн менежментийн системийг сайжруулж, үлдэгдлийг баталгаажуулж баримтжуулах, өр төлбөрийн тайлан, шинжилгээг тогтмол гаргаж, дотоод хяналтыг тогтмол хийх замаар өр төлбөрийн зохистой удирдлагыг хангах.

3.2.6.Бараа материалтай холбоотой

Илрүүлэлт:

Бараа материалын бүртгэлийг аккурал сууриар бүртгээгүй, Сангийн сайдын баталсан маягтаар бараа материалын тайланг эдийн засгийн ангилал бүрээр гаргаж, баталгаажуулаагүй нь ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл тодруулгын иж бүрэн байх, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 (Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ), 20 дугаар зүйлийн 20.2.3 (холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах) дахь заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа материалын бүртгэлийг аккурэл сууриар хөтлөх, Сангийн сайдын баталсан маягтаар бараа материалын тайланг эдийн засгийн ангилал бүрээр гаргаж, баталгаажуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 6 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/ сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Анхан шатын баримтын бүрдэл дутуу					1	70.6						
Авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй					1	249.0						
Цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй							1					
Тээвэр шатахууны зардлыг зарцуулалтад хяналт тавиагүй							1					
Авлагыг барагдуулах урьдчилгаа цалин их хэмжээгээр олгохгүй байх							1					
Үр ашиггүй зардал гаргахгүй байж зорилтод түвшинг мөрдөж ажиллах							1					
Үүссэн өр төлбөрийн зохистой удирдаагүй, барагдуулах төлөвлөгөө боловсруулан ажиллаагүй,							1	932.8				
Сангийн сайдын баталсан маягтаар бараа материалын тайланг эдийн засгийн ангилал бүрээр гаргаж							1					
					2	319.6	6	932.8	-	-	-	-